ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Эрүүгийн хэрэг[1])

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТЭЭР ХҮЧИНГҮЙ БОЛСОН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 13.14 ДҮГЭЭР ЗҮЙЛД ХОЛБОГДОХ ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОВ

САНАМЖ: *Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.*

Шүүхийн шийдвэрийн дугаар: ХШТ/2026/82
Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр
Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь хохирогч С-ийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд нь халдаж илт худал мэдээллийг олон нийтэд, цахим орчинд тараасан гэмт хэрэгт, хохирогч А-тай шаардлага тавих үед нь маргалдаж, улмаар түүнийг түлхэж унаган, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд; “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт[2] зааснаар 1,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 1,000,000 төгрөгөөр торгох ялаар; Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт[3] зааснаар 800 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 800,000 төгрөгөөр торгох ялаар тус шийтгэжээ.

---

[1] Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3870?daterange=2026/01/01%20-%202026/10/22%20&id=3&court_cat=2&bb=1 (Сүүлд үзсэн: 2026.10.22).

[2] Эрүүгийн хууль (2015)-ийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг *“Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”*

[3] Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “*Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”*

2. **Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

3. **Шүүгдэгчийн өмгөөлөгч хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо** "...Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт холбогдох хэргийн талаар дараах тайлбарыг гаргахад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлд зааснаар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохоор хуульчилж, Эрүүгийн хуульд тусгалаа олсон хэм хэмжээ юм. Нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн Хуулийн цэцэд мэдээлэл гаргаж, мэдээллийг хүлээж аваад их суудлын хуралдаанаар хэлэлцээд, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх зүйл, ангийг Үндсэн Хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасан. Уг дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хүчингүй болгосон. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй тохиолдолд хамаарч байгаа учир гэмт хэргийн шинж гэдэг агуулгаар нь хууль зүйн дүгнэлт хийх боломжгүй учир Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасаар дээрх үйлдлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

4. Мөн Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн сэдэлт зорилгын хувьд гэм буруугүйгээр хор уршиг учруулсан үйл баримт байгаа эсэх, мөн гэмт хэргийн сэдэлт зорилго, түүнийг нотолж байгаа нотлох баримтын хүртээмжтэй байдал, гэмт хэргийн объектив талын шинжийг тодорхойлж байгаа шинжээчийн дүгнэлт хуульд заасан үндэслэл журмыг зөрчсөн, хохирогч өмнө нь гэмтэл авч мэс ажилбарт орж байсан нөхцөл байдлыг ялгаж салгахгүйгээр хөнгөн хохирол учруулсан гэж зүйлчилсэн нь хэргийн бодит байдалд нийцээгүй, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн" гэв.

5. **Хяналтын шатны шүүхээс** Прокуророос шүүгдэгч нь хохирогч С-ийг бусдыг өрөөндөө оруулж зэрлэгээр зоджээ" гэсэн гарчигтай хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд нь халдсан илт худал мэдээллийг фейсбүүк цахим орчинд олон нийтэд тараасан гэж Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдсэнийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт[4] заасан "тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон" үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нь зүйтэй. (19)[5]

6. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн "Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь

[4] ЭХХШтХ 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтад тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон бол шүүх хэргийг хэрэгсэхгүй болгоно".
[5] "Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр" хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн шийдвэрийн цогцолборын дугаар болно.

хэсэг[6], Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт[7], мөн зүйлийн 17 дахь заалт[8], Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн[9] холбогдох заалтыг тус тус зөрчсөн" тухай 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг[10] Монгол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч, 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулиар "Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл"-ийг хүчингүй болсонд тооцож, 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 23/1418 дугаартай "Төрийн мэдээлэл"-д нийтлэгдсэн нь Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д "Тухайн хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол уг шийдвэр "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно." гэж заасны дагуу хүчин төгөлдөр болсон байна.(20).

7. Иймд шүүгдэгчийн өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлын "...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн..., шүүгдэгчийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй..." гэх хэсгийг хэрэгсэхгүй болгож, "...худал мэдээлэл тараасан гэх үйлдлийг хэрэгсэхгүй болгуулах..." гэсэн хэсгийг хангаж, шийтгэх тогтоол, магадлалд зохих өөрчлөлтийг оруулахаар шийдвэрлэлээ. (25).

---o0o---

[6] Монгол Улсын Үндсэн Хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "*Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.*"

[7] Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт *"Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;"*

[8] Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт *"Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;"*

[9] Монгол Улсын Үндсэн Хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг *"Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино."*